



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Архангай аймгийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудитын тайлан

Аудитын код: АРА-2022/11/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:

www.audit.mn

Архангай аймаг .

2022 он

Архангай аймаг дахь Төрийн аудитын газрын тэргүүлэх аудитор: Т.Байгалмаа
Утас: 70333141 Цахим хаяг: Baigalmaat@audit.gov.mn

Аудитын менежер: Д.Нэргүйбаатар
Утас: 70332680 Цахим хаяг: Nerguibaatard@audit.gov.mn

Ахлах аудитор: Х.Алтанчимэг
Утас: 90060105 Цахим хаяг: Altanchimegkh@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1. Аудитын санал дүгнэлт	1
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	2
3. Аудитын тайлан.....	11
3.1 Ерөнхий зүйл.....	11
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	11
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	12
3.4 Материаллаг байдал	12
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга.....	12
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	12
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг.....	14
3.8 Аудитын гол асуудал	14
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	14
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	15
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	15
4. Аудитын илрүүлэлт	16
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	17

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ГБХЗХГ	Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар
ЗДТГ	Засаг даргын тамгын газар



**АРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

65130 Цэцэрлэг, Архангай аймаг
Утас/Факс: 976-70333141
И-мэйл: arkhangai@audit.gov.mn

2022.02.14 № 3
танай _____-ны № _____-т

ГЭР БҮЛ, ХҮҮХЭД, ЗАЛУУЧУУДЫН
ХӨГЖЛИЙН ГАЗРЫН ДАРГА
Б.БОЛОРМАА ТАНАА

Аудитын санал дүгнэлт

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Архангай аймгийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Архангай аймгийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Т.БАЙГАЛМАА

2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	89,328,522.92	78,086,749.44
35	БАРАА МАТЕРИАЛ	89,328,522.92	78,086,749.44
35100	Түүхий эд материал	2,921,770.00	5,186,410.00
35130	Эм боох материал	2,921,770.00	5,186,410.00
35400	Хангамжийн материал	86,406,752.92	72,900,339.44
35410	Бичиг хэргийн материал	15,197,175.00	6,574,270.00
35420	Аж ахуйн материал	67,194,609.92	62,886,561.44
35430	Сэлбэг хэрэгсэл	689,000.00	689,000.00
35450	Барилгын засварын материал	1,803,500.00	1,795,500.00
35460	Хүнсний материал	314,240.00	195,850.00
35470	Бусад хангамжийн материал	1,208,228.00	759,158.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	949,593,326.44	1,046,852,802.72
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	949,593,326.44	1,046,852,802.72
39200	Биет хөрөнгө	806,367,326.44	904,199,052.74
39201	Барилга, байгууламж, орон сууц	700,813,453.17	750,481,499.17
39202	Хуримтлагдсан элэгдэл	-63,966,184.22	-96,452,896.94
39203	Авто-тээврийн хэрэгсэл	63,500,000.00	63,500,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-46,854,166.69	-15,770,833.35
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	139,556,258.00	172,996,433.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	-74,007,728.83	-60,729,165.89
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	115,891,778.00	113,089,029.50
39208	Хуримтлагдсан элэгдэл	-49,042,340.00	-48,691,571.20
39214	Бусад үндсэн хөрөнгө	38,232,152.00	38,232,152.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-18,255,894.99	-14,673,093.55
39217	Ном	500,000.00	2,217,500.00
39300	Биет бус хөрөнгө	143,226,000.00	142,653,749.98
39301	Програм хангамж	4,837,000.00	4,837,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-2,437,000.00	-3,009,250.02
39303	Бусад биет бус хөрөнгө	140,826,000.00	140,826,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	1,038,921,849.36	1,124,939,552.16
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	1,038,921,849.36	1,124,939,552.16
51	Засгийн газрын хувь оролцоо	1,038,921,849.36	1,124,939,552.16
51100	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	324,360,727.09	324,360,727.09
51200	Хуримтлагдсан үр дүн	403,182,738.59	489,200,441.39
51210	Өмнөх үеийн үр дүн	445,807,615.38	403,182,738.59
51220	Тайлант үеийн үр дүн	-42,624,876.79	86,017,702.80
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	311,378,383.68	311,378,383.68
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	1,038,921,849.36	1,124,939,552.16

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	423,809,900.00	693,812,761.40
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	6,420,000.00	173,969,361.40
120	Нийтлэг татварын бус орлого	6,420,000.00	173,969,361.40

120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	6,420,000.00	5,930,000.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	4,990,000.00	5,930,000.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	0.00	165,919,161.40
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	0.00	2,120,200.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	417,389,900.00	519,843,400.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	323,323,800.00	375,206,700.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	323,323,800.00	375,206,700.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	16,837,200.00	47,407,800.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	150,000.00	18,105,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	16,687,200.00	29,302,800.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	77,228,900.00	97,228,900.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	77,228,900.00	97,228,900.00
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	466,434,776.79	606,565,708.43
21	УРСГАЛ ЗАРДАЛ	466,434,776.79	606,565,708.43
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	449,663,964.79	532,820,681.43
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	179,692,656.00	215,661,500.00
210101	Үндсэн цалин	179,692,656.00	215,661,500.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	43,701,307.00	29,114,300.00
210201	Тэтгэврийн даатгал	38,015,807.00	20,487,800.00
210202	Тэтгэмжийн даатгал	1,421,400.00	2,156,700.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,161,300.00	1,725,300.00
210204	Ажилгүйдлийн даатгал	260,700.00	431,300.00
210205	Эрүүл мэндийн даатгал	2,842,100.00	4,313,200.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	61,109,303.00	59,734,691.00
210301	Гэрэл, цахилгаан	6,119,557.00	4,582,067.00
210302	Түлш, халаалт	52,816,441.00	52,816,487.00
210303	Цэвэр, бохир ус	2,173,305.00	2,336,137.00
2104	Хангамж, бараа материалын зардал	11,715,324.10	18,023,969.14
210401	Бичиг хэрэг	3,669,994.10	5,517,295.00
210402	Тээвэр, шатахуун	3,326,840.00	6,939,826.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,708,290.00	2,760,400.00
210404	Ном, хэвлэл	0.00	421,400.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	180,000.00	721,000.00

210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,830,200.00	1,664,048.14
2105	Нормативт зардал	5,060,530.00	13,002,386.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	2,253,250.00	6,233,830.00
210502	Хоол, хүнс	2,527,280.00	4,733,394.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	280,000.00	2,035,162.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	2,670,265.00	1,556,450.00
210604	Урсгал засвар	2,670,265.00	1,556,450.00
2107	Томиллолт, зочны зардал	536,000.00	636,200.00
210702	Дотоод албан томиллолт	536,000.00	636,200.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	64,952,724.00	97,426,059.34
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	63,620,724.00	95,969,077.34
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	420,000.00	450,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	180,000.00	200,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	150,000.00	150,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	80,000.00	80,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	467,000.00	526,982.00
210807	Газрын төлбөр	35,000.00	50,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	80,225,855.69	97,665,125.95
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,462,462.00	861,640.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	4,506,300.00	12,263,951.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	74,257,093.69	84,539,534.95
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	16,770,812.00	73,745,027.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	487,500.00	56,247,800.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	0.00	55,047,800.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	487,500.00	1,200,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	0.00	17,497,227.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	0.00	17,497,227.00
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	-42,624,876.79	87,247,052.97
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	0.00	1,229,350.17
225001	Үндсэн хөрөнгө, бараа материал худалдсаны гарз	0.00	1,229,350.17
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	-42,624,876.79	86,017,702.80

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
D01	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	324,360,727.09	311,378,383.68	403,182,738.59	1,038,921,849.36
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	324,360,727.09	311,378,383.68	403,182,738.59	1,038,921,849.36
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	86,017,702.80	86,017,702.80

D09	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	324,360,727.09	311,378,383.68	489,200,441.39	1,124,939,552.16
-----	---------------------------------------	----------------	----------------	----------------	------------------

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	422,379,900.00	525,773,400.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	4,990,000.00	5,930,000.00
120	Нийтлэг татварын бус орлого	4,990,000.00	5,930,000.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	4,990,000.00	5,930,000.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	4,990,000.00	5,930,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	417,389,900.00	519,843,400.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	323,323,800.00	375,206,700.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	323,323,800.00	375,206,700.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	16,837,200.00	47,407,800.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	150,000.00	18,105,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	16,687,200.00	29,302,800.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	77,228,900.00	97,228,900.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	77,228,900.00	97,228,900.00
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	415,868,100.00	508,664,200.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	415,868,100.00	508,664,200.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	399,097,288.00	434,919,173.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	142,139,600.00	215,661,500.00
210101	Үндсэн цалин	142,139,600.00	215,661,500.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	19,188,700.00	29,114,300.00
210201	Тэтгэврийн даатгал	13,503,200.00	20,487,800.00
210202	Тэтгэмжийн даатгал	1,421,400.00	2,156,700.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,161,300.00	1,725,300.00
210204	Ажилгүйдлийн даатгал	260,700.00	431,300.00
210205	Эрүүл мэндийн даатгал	2,842,100.00	4,313,200.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	61,109,303.00	59,734,691.00
210301	Гэрэл, цахилгаан	6,119,557.00	4,582,067.00
210302	Түлш, халаалт	52,816,441.00	52,816,487.00
210303	Цэвэр, бохир ус	2,173,305.00	2,336,137.00
2104	Хангамж, бараа материалын зардал	8,796,420.00	9,736,100.00
210401	Бичиг хэрэг	2,778,200.00	1,288,200.00
210402	Тээвэр, шатахуун	926,800.00	878,500.00

210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,708,290.00	2,760,400.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	180,000.00	821,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,203,130.00	3,988,000.00
2105	Нормативт зардал	2,500,000.00	4,100,000.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	0.00	750,000.00
210502	Хоол, хүнс	0.00	3,350,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	3,350,000.00	500,000.00
210604	Урсгал засвар	3,350,000.00	500,000.00
2107	Томилолт, зочны зардал	536,000.00	636,200.00
210702	Дотоод албан томилолт	536,000.00	636,200.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	152,884,300.00	88,559,782.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	151,447,300.00	87,002,800.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	420,000.00	450,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	180,000.00	200,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	150,000.00	150,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	80,000.00	80,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	572,000.00	626,982.00
210807	Газрын төлбөр	35,000.00	50,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	8,592,965.00	26,876,600.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	6,300,455.00	26,876,600.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	16,770,812.00	73,745,027.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	487,500.00	56,247,800.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	0.00	55,047,800.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	487,500.00	1,200,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	16,119,597.00	17,494,209.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	16,119,597.00	17,494,209.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	163,715.00	3,018.00
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	163,715.00	3,018.00
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	6,511,800.00	17,109,200.00
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	6,511,800.00	17,109,200.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	6,511,800.00	17,109,200.00
2200	Дотоод эх үүсвэрээр	6,511,800.00	17,109,200.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	6,511,800.00	17,109,200.00
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-6,511,800.00	-17,109,200.00

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэлийн тайлан
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	478,435,600.00	460,868,373.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	478,435,600.00	460,868,373.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	422,187,800.00	404,620,573.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	215,661,500.00	215,661,500.00
210101	Үндсэн цалин	215,661,500.00	215,661,500.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	29,114,300.00	29,114,300.00
210201	Тэтгэврийн даатгал	20,487,800.00	20,487,800.00
210202	Тэтгэмжийн даатгал	2,156,700.00	2,156,700.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,725,300.00	1,725,300.00
210204	Ажилгүйдлийн даатгал	431,300.00	431,300.00
210205	Эрүүл мэндийн даатгал	4,313,200.00	4,313,200.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	77,228,900.00	59,734,691.00
210301	Гэрэл, цахилгаан	11,340,000.00	4,582,067.00
210302	Түлш, халаалт	53,516,600.00	52,816,487.00
210303	Цэвэр, бохир ус	12,372,300.00	2,336,137.00
2104	Хангамж, бараа материалын зардал	6,948,100.00	6,948,100.00
210401	Бичиг хэрэг	1,288,200.00	1,288,200.00
210402	Тээвэр, шатахуун	878,500.00	878,500.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,760,400.00	2,760,400.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	821,000.00	821,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,200,000.00	1,200,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	500,000.00	500,000.00
210604	Урсгал засвар	500,000.00	500,000.00
2107	Томилолт, зочны зардал	636,200.00	636,200.00
210702	Дотоод албан томилолт	636,200.00	636,200.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	89,630,000.00	89,556,982.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	88,000,000.00	88,000,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	450,000.00	450,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	200,000.00	200,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	150,000.00	150,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	80,000.00	80,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	700,000.00	626,982.00
210807	Газрын төлбөр	50,000.00	50,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	2,468,800.00	2,468,800.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,468,800.00	2,468,800.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	56,247,800.00	56,247,800.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	56,247,800.00	56,247,800.00

213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	55,047,800.00	55,047,800.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,200,000.00	1,200,000.00
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	478,435,600.00	460,868,373.00
31	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	375,206,700.00	375,203,682.00
310003	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	375,206,700.00	375,203,682.00
32	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	97,228,900.00	79,734,691.00
320001	Орон нутгийн төсвөөс	97,228,900.00	79,734,691.00
35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	6,000,000.00	5,930,000.00
350001	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	6,000,000.00	5,930,000.00
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1	1
610001	Төсвийн байгууллага	1	1
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	24	23
620001	Удирдах ажилтан	1	1
620002	Гүйцэтгэх ажилтан	6	6
620003	Үйлчлэх ажилтан	17	16
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	24	23
650001	Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	7	7
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	17	16

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	47,407,800.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	33,655,800.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	33,655,800.00
2104	Хангамж, бараа материалын зардал	2,788,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,788,000.00
2105	Нормативт зардал	4,100,000.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	750,000.00
210502	Хоол, хүнс	3,350,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,360,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,360,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	24,407,800.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	24,407,800.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	13,752,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	13,752,000.00
223001	Бусад хөрөнгө	13,752,000.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	47,407,800.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	47,407,800.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	18,105,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	29,302,800.00

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Архангай аймгийн ГБХЗХГ-ын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд орлогын төвлөрүүлэлт, шилэн данстай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Архангай аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Х.Алтанчимэг гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Д.Нэргүйбаатар, дарга, тэргүүлэх аудитор Т.Байгалмаа нар тус тус хэрэгжүүлсэн.

Архангай аймгийн ГБХЗХГ нь 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 18-ны өдрийн 05 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Архангай аймгийн ГБХЗХГ нь Хүүхэд хамгааллын тухай хуульд заасны дагуу харьяалах нутаг дэвсгэртээ хүүхэд хамгаалал, залуучууд, гэр бүлийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг, Хөдөлмөр нийгмийн хамгааллын яамны багцын харьяа байгууллага юм.

Тус байгууллага нь “Гэр бүлийн хөгжил, тогтвортой байдлыг дэмжих, амьдралын чанарыг сайжруулах болон хүүхдийн эрх хөгжил, хамгааллын үйлчилгээг мэргэжлийн өндөр түвшинд үзүүлэхэд чиглэсэн бодлогын хэрэгжилтийг хангах, залуучуудын хөгжил, нийгмийн оролцоог дэмжихэд оршино” гэсэн зорилт тавин ажилласан байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомжийн хүрээнд 2021 оны 06 сарын 11-ны “Нийгмийн даатгалын тухай сангийн тухай хууль”-ийн нийгмийн даатгалын шимтгэлийн хувь хэмжээнд өөрчлөлт орсон байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэхэд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитороос шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Архангай аймгийн ГБХЗХГ-ын 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2021 оны батлагдсан төсвөөс сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны батлагдсан төсөв 478.4 сая төгрөгөөс 1% буюу 4.7 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70% буюу 3.2 сая төгрөгөөр тогтоосон.

Гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг хянаж үзээд шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Тус байгууллагын 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаар нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 97.3 сая төгрөгөөр буюу 9.3 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан нь үндсэн хөрөнгө, бараа материалын данс байна.

Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он	Өөрчлөлт	Хувь
Бараа материал	89.3	78.1	-11.2	-14.3
Үндсэн хөрөнгө	949.5	1046.8	97.3	9.3
Нийт хөрөнгө	1038.9	1124.9	86.0	7.9
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	1038.9	1124.9	86.0	7.9
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	1038.9	1124.9	86.0	7.9

3.5.1. Бараа материалын үлдэгдэл өмнөх оноос 11.2 сая төгрөг буюу 14.3 хувиар буурсан байна.

Бараа материалын данс нь 89.3 сая төгрөгийн эхний үлдэгдэлтэй ба тайлант онд төсвийн хөрөнгөөр худалдан авсан 90.7 сая төгрөг, бусад байгууллагаас үнэ төлбөргүй хүлээн авсан 2.1 сая төгрөг нийт 92.8 сая төгрөгөөр нэмэгдэж, тайлант онд зарцуулсан 104.1 сая төгрөгөөр хасагдаж, эцсийн үлдэгдэл 78.1 төгрөгийн үлдэгдэлтэй байна.

3.5.2. Үндсэн хөрөнгийн үлдэгдэл өмнөх оноос 97.3 сая төгрөг буюу 9.3 хувиар өссөн байна.

Үндсэн хөрөнгө данс нь 949.5 сая төгрөгийн эхний үлдэгдэлтэй ба тайлант онд төсвийн хөрөнгөөр худалдаж авсан 17.1 сая төгрөг, үнэ төлбөр хүлээн авсан 164.7 сая

төгрөг нийт 181.8 сая төгрөгөөр нэмэгдэж, тайлант хугацаанд байгуулсан 84.5 сая төгрөгийн элэгдлийн дүнгээр буурч 1046.8 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

3.5.3 Цэвэр хөрөнгө өмчийн дүн буурсан нь тайлант хугацааны үр дүнтэй шууд холбоотой байна. Өөрөөр хэлбэл тайлант хугацаанд 86.0 сая төгрөгийн үр дүнг хүлээн зөвшөөрсөн байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр, нийт зарлагыг 510.0 сая төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсөв захирагчийн хүргүүлсэн төсвийн төслийг нийт 31.6 сая төгрөгөөр бууруулж нийт зардлыг 478.4 сая төгрөгөөр хянаж баталжээ.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн 3 хөтөлбөрийн 3 арга хэмжээг хэрэгжүүлэхэд 478.4 сая төгрөгийн төсөв батлагджээ. Гүйцэтгэлээр улсын төсвөөс 375.3 сая төгрөг, орон нутгийн төсвөөс 97.2 сая төгрөг, төсөвт байгууллагын өөрийн орлогоор 5.9 сая төгрөг, нийт 478.4 сая төгрөгийн орлого, санхүүжилтийн эх үүсвэрийг бүрдүүлснээс 460.8 сая төгрөгийг урсгал үйл ажиллагаанд зарцуулан, 17.6 сая төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн байна.

Төвлөрүүлэх шилжүүлэг нь байр ашиглалттай холбоотой 17.6 сая төгрөгийн зардлыг хэмнэсэн байна. Хэмнэлтийг байр ашиглалтын зардлын батлагдсан төсөв 77.2 сая төгрөгтэй харьцуулахад 22.6% байгаа нь Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолын 1.8 заалттай нийцэж байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант жилд нэмэлт санхүүжилтийн дансаар “Хөөрхөн зүрхнүүдийн аян” ТББ-аас 0.2 сая төгрөг, Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн ерөнхий газраас 26.8 сая төгрөг, НҮБ-аас түр хамгаалах байрны зорилтот бүлгийн болон хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд үйлчилгээ үзүүлэхэд ээлтэй болох төслөөс 17.8 сая төгрөг, ХНХЯ-аас “Хүүхэд, эмэгтэйчүүдийн эсрэг гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх” төсөлд 2.5 сая төгрөг, нийт 47.4 сая төгрөгийн гүйлгээ хийгдснийг анхан шатны баримтаар түүвэрлэн шалгав.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Тус байгууллага нь 2021 онд “Гэр бүл, хүүхэд, залуучуудын асуудлаар үүрэг хүлээгчдийн анхдугаар зөвлөгөөн”-ийг хүүхдийн аливаа эрсдэлээс хамгаалах үйл ажиллагаанд үүрэг хүлээгчдийн хамтын ажиллагааг өргөжүүлэх хариуцлагыг нэмэгдүүлэх бодлогын хэрэгжилтийг сайжруулах зорилготой зохион байгуулсан байна.

Мөн Монгол улсад Залуучуудын байгууллагын 100 жилийн ойн арга хэмжээг Улаанбаатар хот дахь аймгийн Залуучуудын холбоо, аймгийн ЗДТГ-тай хамтарч зохион байгуулсан байна.

3.8 Аудитын гол асуудал

Тус байгууллага нь жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан стратегийн зорилтуудыг хангахад чиглэсэн 4 үндсэн зорилтын хүрээнд 71 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, дэвшүүлсэн зорилт, төлөвлөсөн арга хэмжээг 100.0 хувь хэрэгжүүлсэн байна.

Тайлант онд хэрэгжүүлэх хөтөлбөр, арга хэмжээнд зориулан нийт 478.4 сая төгрөгийг зарцуулахаар төлөвлөж, гүйцэтгэлээр нийт 460.8 сая төгрөгийг зарцуулж, 96.3 хувийн биелэлттэй.

Тус байгууллага нь Хүүхэд хамгааллын тухай хууль, Хүүхдийн эрхийн тухай хууль, Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хуульд заасны дагуу хүүхэд хамгаалал, залуучууд, гэр бүлийн хөтөлбөр арга хэмжээг хэрэгжүүлэн ажилладаг бөгөөд энэ ажилд тайлант онд 88.0 сая төгрөгийг төлөвлөж зарцуулсан байна.

Аудитын явцад санхүүгийн тайлангийн аудитад баримтлах ерөнхий чиглэлийн дагуу дараах судалгааг авч үнэллээ. Үүнд:

1. Төсвийн хэмнэлтийн талаар авсан арга хэмжээ, түүний үр дүн судалгааг авч үзэхэд батлагдсан төсвийн хүрээнд зардлыг зарцуулсан байна. Үүнд:
 - Албан конторын тавилга хөрөнгө худалдан авахад 3.3 сая төгрөг зарцуулсан байна.
 - Тайлант жилд тогтмол зардлаас 17.5 сая төгрөгийн хэмнэлт гаргаж орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн нь батлагдсан төсвийн 3.6 хувийг эзэлж байна.
 - Шагнал, албан томилолт, бичиг хэргийн зардлыг батлагдсан төсвийн хүрээнд зарцуулалтыг гаргасан байна.
2. Ажлын байрны түрээсийн хувьд: ГБХЗХГ-т бүртгэлтэй үйлчилгээний 35 мкв барилгыг түрээслүүлж сард 0.35 сая төгрөг, жилд 4.2 сая төгрөгийн орлого төлөвлөж, гүйцэтгэлээр 3.0 сая төгрөгийг төвлөрүүлж, төлөвлөснөөс 1.2 сая төгрөг дутуу байгаа нь тайланд жилд ковид-19 цар тахал гарч ААНБ-уудын ажиллагаа зогссонтой холбоотой байна. Гүйцэтгэлээр төлөвлөрсөн санхүүжилтийг үндсэн үйл ажиллагаандаа зарцуулсан байна.
3. Ковид-19 цар тахалтай холбоотой хандивын хувьд: НҮБ-ын хүүхдийн сангаас 2.1 сая төгрөгийн маск, хамгаалалтын хувцас хэрэглэл хандиваар ирж 0.5 сая төгрөгийн бараа материалыг зарцуулсан байна.
4. Суудлын автомашин ашиглалтын хувьд: 2014, 2019 онд үйлдвэрлэгдсэн 63.5 сая төгрөгийн Делика, Бага оврын автобус 2 автомашинтай бөгөөд шатахууны зардалд 0.8 сая төгрөгийг зарцуулсан, орон тооны жолоочтой цалингийн зардалд 6.1 сая төгрөгийг олгосон байна. Эдгээр автомашинуудыг бусдад түрээслүүлж 2.8 сая төгрөгийн орлого төвлөрүүлж зарцуулсан.

Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолын хэрэгжилтийг шалгахад байгууллага нь тайлант онд байр ашиглалттай холбоотой зардлыг 17.5 сая төгрөгөөр хэмнэсэн нь батлагдсан АРА-2022/11/НА-СТА-ТШЗ

төсөв 77.2 сая төгрөгтэй харьцуулахад 22.6% байгаа нь Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолын 1.8 заалттай нийцэж байна.

Харин бусад судалгаанд холбогдох мэдээлэлгүй байхгүй тул судалгааг гаргаагүй байна.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Санхүүгийн тайлангийн аудитаар Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг шалгаж илэрсэн зөрчилд зөвлөмж хүргүүлээ.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Архангай аймгийн ГБХЗХГ нь тайлант хугацаанд шилэн дансанд оруулбал зохих 146 мэдээллээс 135 мэдээллийг хугацаанд нь байршуулсан байна. Харин 11 мэдээллийг хугацаа хоцроон байршуулсан нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3 “4.1.3.тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх” гэсэн заалттай нийцэхгүй байна.

Иймд аудитаас Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3 дахь заалтыг хэрэгжүүлж, мэдээллийг хуулийн хугацаанд тогтмол мэдээлж хэвших зөвлөмжийг хүргүүлж, биелэлтийг төрийн аудитын газарт 2022 оны 6 дугаар сарын 01 -ний өдрийн дотор ирүүлнэ үү.

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Тайлант онд батлагдсан төсвийн 10.0 хувь буюу 17.6 сая төгрөгийн хэмнэлт бий болгож төсөвт буцаан төвлөрүүлсэн нь Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолын 1.1 дэх заалттай нийцэж байна.

“Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай” Засгийн газрын 43 дугаар тогтоолтой нийцүүлэн үзэхэд Гэр бүл, хүүхэд, залуучуудын газар нь 3.3 сая төгрөгөөр тавилга, эд хогшил бэлтгэж тус тогтоолын 1.4 дэхь заалтыг зөрчсөн тул албан шаардлага хүргүүлээ.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн 4 дүгээр зүйлийн 4.1.3 дахь заалттай нийцсэн байна гэж дүгнэлээ.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх жилийн санхүүгийн тайлангийн аудитаар 2 заалт бүхий зөвлөмж хүргүүлснийг бүрэн хэрэгжүүлж биелэлтийг 2021 оны 06 сарын 15-ны А/15 тоот бичгээр ирүүлсэн байна.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарах асуудалгүй байна.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 3.8 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс аудитын явцад 0.4 сая төгрөгийг залруулж 3.4 сая төгрөгийн зөрчилд албан шаардлага хүргүүлж, шилэн дансны хуулийн хэрэгжилттэй холбоотой болон бусад 2 зөрчлийг давтан гаргахгүй зөвлөмжийг хүргүүлж байна.

4.1 Залруулсан алдаа

Аудитын явцад Орлого үр дүнгийн тайланд 0.4 сая төгрөгийн эм боох материалын зардлыг үнэ төлбөргүй гарсан зардалд бүртгэснийг залруулга хийлгэлээ.

4.2 Албан шаардлага

Төсвийн хөрөнгөөр 3.3 сая төгрөгийн хөрөнгө худалдан авахдаа төсөвт зохицуулалт хийгээгүй бараа үйлчилгээний зардлаас бэлтгэсэн нь Сангийн сайдын 2018 оны 134-р тушаал, Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолын 1.5 дахь заалтыг зөрчсөн байна.

4.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

4.3.1 Зардлын данстай холбоотой асуудал

Илрүүлэлт:

Хүүхэд хамгааллын хөтөлбөрт зарцуулахаар төлөвлөсөн зардлыг анхан шатны баримтаас тулган шалгахад зардлын төсвийн тооцоо судалгааг бодитоор тооцдоггүй зарцуулалтын тайланг үнэн зөв гаргадаггүй, арга хэмжээ зохион байгуулсан ажлын тайлан нотлох баримт хангалтгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Зардлын тооцоо судалгааг үнэн зөв, оновчтой бодитоор тооцож, хэрэгжүүлсэн ажлын тайлан мэдээг нотлох баримтаар бүрэн баталгаажуулж ажиллах

4.3.2 Орлогын данстай холбоотой асуудал

Илрүүлэлт:

Тайлант жилд 6,000.0 мянган төгрөгийн орлого төвлөрүүлэхээс 5930.0 мянган төгрөгийн төвлөрүүлж зарцуулсан нь төлөвлөснөөс 70.0 мянган төгрөгөөр дутуу байна.

Өгсөн зөвлөмж:

Төлөвлөсөн орлогыг бүрэн төвлөрүүлж ажиллах

Зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 6 дугаар сарын 01 -ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	ГБХЗХГазар	5	3.8	1	0.5			1	3.3	3	